



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/06

Чойр

Эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллага, аж ахуй нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмж"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтан, албан хаагчдын гэр бүл, хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих талаар санал санаачлага гарган ажиллах чиг үүрэг бүхий зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Гишүүд:

Б.Нэргүйцэцэг

(Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Д.Оюунсайхан

(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Г.Энххишиг

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Э.Хулан

(Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)

Б.Гүнжидмаа

(Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Н.Оюунбат

(Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, ахмад)

В.Баярсайхан

(Нийтлэг үйлчилгээний албаны менежер)

О.Мөнгөнчимэг

Нарийн бичгийн дарга:

(Хууль, эрх зүйн хэлтсийн
Архивын тасгийн
цахимжуулалтын ажилтан)

Г.Дашжаргал
(Нийгмийн бодлогын хэлтсийн
мэргэжилтэн)

2.Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр, хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, жил бүрийн батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан, тайланг бүтэн жилээр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэн ажиллахыг Зөвлөлийн дарга (Б.Нэргүйцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны А/24 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



~~Д.СОДНОМ~~